

**ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	0
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-54
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	55-94

---

1.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/	55
2.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	55-94

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Инновац, цахим бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 06-ны  
өдөр /Лхагва гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 11 гишүүнээс 6 гишүүн хүрэлцэн ирж, 54.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 00 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ц.Сэргэлэн, Ч.Ундрам;

Чөлөөтэй: Х.Ганхуяг;

Эмнэлгийн чөлөөтэй: Э.Бат-Амгалан.

**Нэг.Байнгын хорооны тогтоолын төсөл /Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай/**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

**Хоёр.Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.05.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх С.Тэнгис, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Л.Батмөнх, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ, референт П.Болорцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

*Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**1.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**2.Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**3.Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**4.Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **5.Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** 1.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн, Э.Батшугар, Н.Ганибал, Ц.Идэрбат, Б.Саранчимэг нарын /цаашид “Ажлын хэсэг” гэх/ гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.5.5 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 17.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, дугаарыг өөрчлөх.

“**2 дугаар зүйл.**Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх” гэснийг “энэ тухай бүртгэлд тэмдэглэх” гэж тус тус өөрчлөх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **6.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**7.Байгаль орчноо хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байгаль орчноо хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**8.Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**9.Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 2

Бүгд: 6

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**10.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**11.Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтын, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**12.Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

**13.Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

“1 дүгээр зүйл. Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “худалдах, зээлдүүлэх гэрээ,” гэснийг “худалдах, зээлдүүлэх гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр,” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3 дахь заалтын “нотолгоо бичгээр” гэснийг “нотолгоог бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	3
Бүгд:	6

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	2
Бүгд:	6

66.7 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	2
Бүгд:	6

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **14.Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **15.Виртуаль хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Виртуаль хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**16.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**17.Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн, 90 дүгээр зүйлийн 90.2, 90.3 дахь хэсгийн, 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 253 дугаар зүйлийн 253.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 255 дугаар зүйлийн 255.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан



цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2 дахь заалтын “мэдээллийн сүлжээгээр” гэснийг “цахим хэлбэрээр” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**3 дугаар зүйл.**Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийн “амаар болон бичгээр” гэснийг, 145 дугаар зүйлийн 145.1.9 дэх заалтын “бичгээр” гэснийг, 241 дүгээр зүйлийн 241.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

### **18.Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Газрын тосны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**19.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.6, 38.7 дахь хэсгийн, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**20.Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын, 8.6 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 55 дугаар зүйлийн 55.1, 55.3 дахь хэсгийн, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн, 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн, 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.5, 69.6, 69.7 дахь хэсгийн, 70 дугаар зүйлийн 70.2, 70.3, 70.4 дэх хэсгийн, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийн, 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтын, 78.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 19.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.4.6 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 75 дугаар зүйлийн 75.1, 75.2 дахь хэсгийн “бичгээр” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “бичгээр хүссэн тохиолдолд” гэснийг тус тус хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**21.Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**22.Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийн “6.3” гэснийг “6.2.2” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төсөлд тусгасан хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг заасан зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**23.Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**24. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**25. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**26. Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**27. Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Жолоочийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**28. Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн, 6.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн, 6.3 дугаар зүйлийн 4 дэх

хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 5.2 дугаар зүйлийн 10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 5.5 дугаар зүйлийн 19.3 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 3 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

**“3 дугаар зүйл.**Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3.7 дахь заалтын “тоон” гэснийг “цахим” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

### **29.Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**30.Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**31.Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ирээдүйн өв сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**32.Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**33.Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**34.Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Концессын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**35.Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**36.Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**37.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн “29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4



Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**38.Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын хилийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**39.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**40.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**41.Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**42.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9 дэх хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “бүрэн бүтэн, үнэн зөв байдлыг хангаж цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэснийг “цахим хуудсандаа болон нээлттэй мэдээллийн системд” гэж, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг “амаар, эсхүл бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсгийн “танина” гэснийг “таньж, баталгаажуулна. Тус системээр таньж, баталгаажуулсан мэдээллийг хүн, хуулийн этгээдээс цаасан хэлбэрээр шаардахгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл хариуцагч цахим хэлбэрээр бүрдүүлнэ.” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 2  
Бүгд: 6  
66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4, 5 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**43.Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Нийтийн сонсголын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**44.Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нотариатын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**45.Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**46.Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**47.Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**48.Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** 1.Төслийн 2 дугаар зүйлийн “8 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 3 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5  
Татгалзсан: 2  
Бүгд: 7  
71.4 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Нөхөрлөлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**49.Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Олон нийтийн радио телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**50.Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Органик хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**51.Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсгийн “бичгээр буюу цахим шуудангаар” гэснийг “бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь хэсгийн “бичгээр” гэснийг “бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**52.Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Өрсөлдөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**53.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**2 дугаар зүйл.**Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**54.Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“**1 дүгээр зүйл.**Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалтын, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 12.3, 12.4 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалтын, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл

тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Санхүүгийн түрээс /лизинг/-ийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **55.Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Соёлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

#### **56.Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.**Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, мөн зүйлийн 8.8 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 3

Бүгд: 7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Сууц өмчлөгчдийн холбооны эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**57.Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**58.Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 62 дугаар зүйлийн 62.5 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Татварын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**59.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**60.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 1 дүгээр зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

**“1 дүгээр зүйл.**Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай 4 дэх заалт нэмсүгэй.”

“4/шинжээчийн мэргэжил, албан тушаал, шинжилгээ хийсэн газар, он, сар, өдөр, хугацаа.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	3
Татгалзсан:	4
Бүгд:	7

42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Э.Батшугар:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	3
Бүгд:	7

57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн:	4
Татгалзсан:	3
Бүгд:	7

57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

### **111.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-г заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3



Татгалзсан: 4  
Бүгд: 7  
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

**Э.Батшугар:** Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 4  
Бүгд: 7  
42.9 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд тооцно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**112.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**113.Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “дарга нь” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**114.Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

**Э.Батшугар:** Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

“2 дугаар зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**115.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**116.Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.**Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3  
Татгалзсан: 4  
Бүгд: 7  
42.9 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

### **117.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**118.Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**119.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

**120.Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар:**

Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

**Э.Батшугар:** Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 4  
Татгалзсан: 3  
Бүгд: 7  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

*Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.*

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 14 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 40 минут үргэлжилж, 11 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 63.6 хувийн ирцтэйгээр 14 цаг 40 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Э.БАТШУГАР

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 12 дугаар сарын 06-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим, 12 цаг 00 минут

### **ИННОВАЦ, ЦАХИМ БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Э.Батиугар:** Байнгын хорооны эрхэм гишүүдэд энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 11.6-д заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

28 дугаар тойрог Батиугар, 12 дугаар тойрог Ганибал, 29 дүгээр тойрог Доржханд, 22 дугаар тойрог Саранчимэг, 28 дугаар тойрог Учрал, 23 дугаар тойрог Чинбүрэн. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүд олонх хүрэлцэн ирсэн тул Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудал танилцуулъя. 2 асуудал байгаа.

Эхний асуудал нь “Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл.

2 дугаар асуудал нь, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчилтэй арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн

даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал.

**“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.**

Тогтоолын төсөл та бүхэнд тараасан байгаа. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүд байна уу? Нэрээ өгнө үү. Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү? Алга байна.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан гишүүд үг хэлж дууслаа.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан санал хураалт явуулъя. Санал хураалтын томъёолол.

**“Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сард Инновац, цахим бодлогын байнгын хорооны хэлэлцэх асуудлын цаглавар батлах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.**

66,7 хувиар батлагдлаа.

12.03 цаг

Дараагийн асуудалдаа оръё.

**Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл,**



**зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.**

Их Хурлын даргын чуулган дээр чиглэл өгсний дагуу Хууль зүйн байнгын хороо бас холбогдох хуулиудыг хэлэлцсэн байгаа. Тэгээд Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Учрал танилцуулна.

**Н.Учрал:** Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 06 дугаар сарын 09, 15-ны өдрүүдэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд хэлэлцүүлгийн явцад хуралдаан даргалагчаас дээрх хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсөн билээ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.10 дахь хэсэгт заасан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний 38 хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн хуралдаанаар явуулсан бөгөөд Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцсэн болно.

Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан саналуудыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд тухайлбал Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд бичгээр гэсний дараа эсхүл цахим хэлбэрээр гэж нийтлэг байдлаар тусгахаар оруулж байгаа өөрчлөлт нь тухайн хуулиар зохицуулсан харилцааны онцлог, шинж чанарыг тухай бүр харгалзахгүй, цаашид хууль хэрэглээний явцад тодорхой нөхцөл үүсэж болзошгүй тул хуулийн төсөл бүрийн харилцааг нарийвчлан судалж холбогдох өөрчлөлтийг хийхээр шийдвэрлэсэн.

Мөн хуулийг хэрэглэх явцад үүсэж болзошгүй эрх зүйн үр дагаврыг тооцож, төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай харилцах, аливаа албан харилцаа, иргэд хоорондын гэрээ хэлцэлтэй холбоотой харилцааг тус бүрээр нь ангилж, холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

1. Төрийн байгууллага албан тушаалтан хоорондоо цахим хэлбэрээр мэдээлэл солилцох харилцааг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай нийцүүлж тус хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем болон албаны цахим шууданг ашиглахаар,

2. Хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллага албан тушаалтай харилцах харилцаа, Нийтийн мэдээллийн ил дотоод байдлын тухай хуульд заасан системүүд болон эрх зүйн үр дагавраас хамаарч иргэний ба хууль болон цахим гарын үсгийн тухай хуульд заасан цахим гарын үсэг, тоон гарын үсгийг тус тус хэрэглэхээр,

3. Эрх зүйн үр дагавар багатай эсхүл тухайн салбарын хууль тогтоомжоор баталгааждаг хуульд амаар гүйцэтгэж болохоор тусгасан

харилцаанд аливаа хэлбэр заахгүй байхаар тусгав.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

**Э.Батиугар:** Учрал гишүүнд баярлалаа.

Инновац, цахим бодлогын байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн танилцуулна.

**Ж.Чинбүрэн:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг 2023 оны 06 дугаар сарын 09, 15-ны өдрүүдэд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцсэн бөгөөд анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Инновац, цахим бодлогын байнгын хороонд 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолоор дээрх

хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийг төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Чинбүрэн миний биеийг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Батиугар, Ганибал, Идэрбат, Саранчимэг нар ажиллалаа.

Хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг 2 удаа, ажлын дэд хэсэг 5 удаа хуралдаж, хуулийн төслүүдтэй нэг бүрчлэн танилцсан бөгөөд тус хуулийн төсөлтэй холбоотой хэлэлцүүлэг 1 удаа зохион байгуулж, байгууллага, албан тушаалтнуудаас нийтдээ 184 саналыг авч нэгтгэн судалж, төсөлд тусгах, холбогдох саналуудыг бэлтгэлээ.

Түүнчлэн дээрх хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед хуралдаан даргалагчаас Хууль зүйн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх чиглэл өгсний дагуу тус Байнгын хороо хуулийн төслүүдийг хэлэлцэн санал, дүгнэлт, зарчмын зөв зүйтэй саналуудыг ирүүлсэн байна.

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдэд “бичгээр” гэсний дараа “эсхүл цахим хэлбэрээр” гэж нийтлэг байдлаар тусгахаар оруулж байгаа өөрчлөлт нь тухайн хуулиар зохицуулсан харилцааны онцлог шинж чанарыг тухай бүр харгалзахгүй цаашид хууль хэрэглээний явцад тодорхойгүй нөхцөл үүсэх болзошгүй тул хуулийн төсөл бүрийн харилцааг нарийвчлан судалж, холбогдох өөрчлөлтийг хийлээ.

Ажлын хэсэг хуулийн хэлэлцэх явцад үүсэж болзошгүй эрх зүйн үр дагаврыг тооцож, төрийн байгууллага хооронд болон төрийн байгууллагаас хүн, хуулийн этгээдтэй, хүн, хуулийн этгээдээс төрийн байгууллагатай иргэн

хоорондын харилцааг тус бүрээр нь ангилж, холбогдох өөрчлөлтийг тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцсэн санал, дүгнэлт болон зарчмын зөрөөтэй саналын томъёолол, мөн Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2023 оны 3тоот тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгээс бэлтгэсэн 81 хууль, 1 тогтоолтой холбоотой зарчмын зөрөөтэй 53, найруулгын 1 саналыг та бүхэнд танилцуулахаар тараасан болно. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

**Э.Батшугар:** Чинбүрэн гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Б.Батцэцэг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Б.Бат-Эрдэнэ Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны асуудал хариуцсан ахлах зөвлөх, ажилтны дэд хэсгийн гишүүн, Л.Батмөнх Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх, ажлын дэд хэсгийн ахлагч, С.Тэнгис Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын зөвлөх, Э.Оюунсүрэн Эрүүл мэндийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа төлөвлөлтийн хэлтсийн дарга, Б.Билэгдэмбэрэл Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжил, бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга, Мөнхбаатар Монголын банкны холбооны дэргэдэх Хуульчдын мэргэжлийн зөвлөлийн дарга, Батжаргал Монголын даатгалын холбооны

гүйцэтгэх захирал, Солонгоо Монголын банкны холбооны Хууль, эрх зүй хариуцсан менежер.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Гишүүд хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно.

Хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье.

1. Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэнэ. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

2. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье.

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт асуух саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3. Амьтны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт асуух саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

4. Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуульд хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

5. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэгдсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Үүн дээр ажлын хэсэг зарчмын зөрөөтэй санал байна. Ажлын хэсэг гарсан саналыг томъёоллыг уншъя.

1. Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.5.5 дахь заалтын, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 17.1-д заасан цахим хэлбэрээр” гэж, 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг.

Эхний саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

2 дахь санал уншиж танилцуулъя.

Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, дугаарыг өөрчлөх.

**“2 дугаар зүйл.** Ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.1, 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.4 дэх хэсгийн “өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх” гэснийг “энэ тухай бүртгэлд тэмдэглэх” гэж тус тус өөрчлөх.” Санал хураая. Ажлын хэсгийн санал.

66,7 хувиар дэмжигдлээ. Саяын санал. Мөн өмнөх санал ч гэсэн 66,7 хувиар дэмжигдсэн.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байгаль орчноо хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлд холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр



зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

9. Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаас санал хураалт явуулж эхэлье. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Банк, эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй. Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ. Ажлын хэсгийн санал.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

10. Банк дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг

зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэгдсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Банкны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсгийн, 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 32 дугаар зүйлийн 32.3 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1.3 дахь заалтын, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Сая танилцуулсан саналын томъёоллын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

12. Боловсролын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төсөл төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэгдсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулна. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал хураалт явуулъя, ажлын хэсгийн саналаар.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төсөл зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

13. Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулна.

Төслийн 1, 2 дугаар зүйлийг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулж, зүйлийн дугаарыг өөрчлөх:

**“1 дүгээр зүйл.** Валютын зохицуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “худалдах, зээлдүүлэх гэрээ,” гэснийг “худалдах, зээлдүүлэх гэрээг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр,” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 3 дахь заалтын “нотолгоо бичгээр” гэснийг “нотолгоог бичгээр, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулъя.

Горимын санал Учрал гишүүн гаргая.

**Н.Учрал:** Саяын саналыг дэмжсэн боловч бас нөгөө дэмжсэнд тооцогдсонгүй. Тэгээд дахин санал хураах горимын санал гаргаж байна.

**Э.Батиугар:** Учрал гишүүний гаргасан горимын саналаар эхлээд санал хураалт явуулъя. Санал хураалт.

Горимын санал 66,7 хувиар дэмжигдлээ. Тэгэхээр түрүүн танилцуулсан саналаар ахиж санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

14. Векселийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрийг хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

15. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрийн хэлэлц хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

16. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт,

өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2 дахь хэсгийн, 18 дугаар

зүйлийн 18.1 дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн, 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсгийн, 64 дүгээр зүйлийн 64.2 дахь хэсгийн, 90 дүгээр зүйлийн 90.2, 90.3 дахь хэсгийн, 243 дугаар зүйлийн 243.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 139 дүгээр зүйлийн 139.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 253 дугаар зүйлийн 253.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 255 дугаар зүйлийн 255.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг. Ажлын хэсгийн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зарчмын зөрөөтэй санд 66,7 хувиар дэмжлэг дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2.2 дахь заалтын “мэдээллийн сүлжээгээр” гэснийг “цахим хэлбэрээр” гэж өөрчилсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

66,7 хувиар дэмжигдлээ.

3. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн гарчгийн “амаар болон бичгээр” гэснийг, 145 дугаар зүйлийн 145.1.9 дэх заалтын “бичгээр” гэснийг, 241 дүгээр зүйлийн

241.2 дахь хэсгийн “амаар болон бичгээр” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Санал хураалт дүн танилцуулъя. 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

18. Газрын тосны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулна.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Газрын тосны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулъя.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

19. Даатгалын мэргэжилтэн оролцогчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.6, 38.7 дахь хэсгийн, 39 дүгээр зүйлийн 39.2, 39.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 11 дүгээр зүйлийн 11.3.8 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт явуулъя.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.



20. Даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэгдсэн зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулж эхэлье. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын, 8 дугаар зүйлийн 8.4.3 дахь заалтын, 8.6 дахь хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн 22.4 дэх хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.4 дэх хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.7 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсгийн, 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн, 55 дугаар зүйлийн 55.1, 55.3 дахь хэсгийн, 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийн, 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн, 63 дугаар зүйлийн 63.2 дахь хэсгийн, 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсгийн, 81 дүгээр зүйлийн 81.2.7 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн, “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.6 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.3 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийн, 69 дүгээр зүйлийн 69.5, 69.6, 69.7 дахь хэсгийн, 70 дугаар зүйлийн 70.2, 70.3, 70.4 дэх хэсгийн, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсгийн, 78 дугаар зүйлийн 78.2.2 дахь заалтын, 78.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 19.2-т заасан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.4.6 дахь заалтын “тамга /тэмдэг/” гэсний дараа “, эсхүл цахим гарын үсэг” гэж тус тус

нэмсүгэй.” Санал гарсан ажлын хэсэг, санал хураалт явуулъя.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл.** Даатгалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн, 54 дүгээр зүйлийн 54.1, 54.2, 54.3 дахь хэсгийн, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсгийн, 75 дугаар зүйлийн 75.1, 75.2 дахь хэсгийн “бичгээр” гэснийг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийн “бичгээр хүссэн тохиолдолд” гэснийг тус тус хассугай.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

21. Далай ашиглах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

22. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн санал байна. Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй санал байна, танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “6.3” гэснийг “6.2.2” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

23. Донорын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төсөлтэй 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй санал байна, танилцуулъя.

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 66,7 хувиар дэмжигдлээ.

Хуулийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

24. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

25. Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт

саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

87. Цахим гарын үсгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Цахим гарын үсгийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтын, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтын, 20 дугаар зүйлийн 20.3.3 дахь заалтын, 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 26.3-т заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Идэрбат гишүүний микрофоныг нээе.

**Ц.Идэрбат:** Дэмжиж санал өгсөн боловч төхөөрөмж маань бас буруу алдаа заалаа. Дахин санал явуулж өгнө үү.

**Э.Батиугар:** Идэрбат гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүний горимын санал дэмжигдсэн тул зарчмын зөрөөтэй саналаар ахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

88. Цөмийн энергийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналыг танилцуулна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Цөмийн энергийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 28 дугаар зүйлийн 28.2.7, 28.2.10 дахь заалтын, 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус

нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

89. Шилэн дансны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

90. Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

91. Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

92. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлдээ асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ажлын хэсгийн бэлтгэсэн зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.15 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 20 дугаар зүйлийн 20.2.2 дахь заалтын “бусад техник хэрэгсэл” гэсний дараа “, эрүүл мэндийн программ хангамж” гэж, 43 дугаар зүйлийн 43.2.7 дахь заалтын “бичгээр авах” гэсний дараа “, эсхүл бичгийг цахим хэлбэрээр авах” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57 1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Зарчмын зөрөөтэй 1 санал байна. Ажлын хэсгээс. Үүн дээр санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төсөлд тусгасан хуулийн хүчин төгөлдөр болох хугацааг заасан зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Ажлын хэсгээс орж ирж байгаа тогтоолын төслийн “Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг талаар санал хураалт явуулъя. Тогтоолын төслийг танилцуулъя.

Төслийн 1, 2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1. Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиуд баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Л.Оюун-Эрдэнэ/-т даалгасугай:

1/ Үндэсний цахим шилжилтийг эрчимжүүлж, нийгэм эдийн засгийн бүх салбарт мэдээллийн технологийн дэвшил, финтек, их өгөгдөл, хиймэл оюун ухааныг ашиглах боломжийг нээх, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан олж авах, солилцох боломжтой мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх, цахим гэрээ хэлцэл хийх эрх зүйн орчныг боловсронгуй болгох асуудлаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтан Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх бэлтгэлийг хангаж ажиллах;

2/төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийхтэй холбогдсон дүрэм, журам, эрх зүйн актыг боловсронгуй болгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

3/төрийн үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийн уялдаа холбоог сайжруулах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг

бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох;

4/төрийн цахим үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд операторын горимоор хүргэх цэгийг аймаг, сум, нийслэл, дүүрэг, хороонд байгуулах. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ажлын хэсгийн санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Тогтоолын төслийн 2-т, Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмэх:

2 дахь заалт. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Э.Батшугарт даалгасугай. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ажлын хэсгийн санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Найруулгын чанартай 1 санал байна.

1. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, хэсэг, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

Ажлын хэсгийн санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Одоо Хууль зүйн байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулья.

93. Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “18.4.10,” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо. Санал хураалт.

Хууль зүйн байнгын хороо дэмжсэн санал 57,1 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “гэснийг, 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

**“3 дугаар зүйл.** Авлигын эсрэг хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт явуулъя.

57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

94. Арбитрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж хэлэлцэж эхэлье. Хуулийн төсөл төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “15.2 дахь хэсэг,” гэснийг “15.2 дахь хэсгийн “хүсэлтээ бичгээр” гэсний дараа” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн

байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Арбитрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

**“2 дугаар зүйл.** Арбитрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсгийн “гарын үсэг зурна.” гэснийг “гарын үсгээр баталгаажуулна.” гэж өөрчлөх.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1.Төслийн 2 дугаар зүйлийн 5 дахь заалтад доор дурдсан агуулгатай 47.4 дэх хэсэг нэмэх.

“47.4. Цаасан хэлбэрээр давхар хадгалах цахим баримт бичгийн нэр



төрлийг энэ хуулийн 6.1.11-д заасан жагсаалтад тусгайлан заана.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй санал танилцуулъя.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 2 дахь заалтын 38.2 дахь хэсгийн “хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Учрал гишүүн горимын санал гаргая гэж байна. Учрал гишүүний микрофоныг нээе.

**Н.Учрал:** Саяын саналыг дэмжсэн, тэгэхдээ дэмжээгүйд тооцогдсон байна. Дахиж санал хураах горимын саналтай байна.

**Э.Батиугар:** Учрал гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүн горимын санал гаргая.

**Ц.Идэрбат:** Төхөөрөмж бас гацаад байх шиг байна. Дахин санал хурааж өгнө үү.

**Э.Батиугар:** Идэрбат гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүний горимын санал нь 57,1 хувиар дэмжигдсэн тул зарчмын зөрөөтэй саналаар ахиж санал хураалт явуулъя. Санал хураалт.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

3. Төслийн 3 дугаар зүйлийн “мөн зүйлийн “4.1.14” гэснийг “4.1.15” гэж,” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

96. Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “хэсэг, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” гэснийг “хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 33 дугаар зүйлийн 33.4.2 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим иуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж” тус тус нэмсүгэй.” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн

байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Гэмт хэргээс зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн зүйлийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй санал танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төсөлтэй 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

98. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “заалт, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулттай гишүүн

байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

99. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөлтэй 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.2 дахь заалт, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 66 дугаар зүйлийн 66.3.2, 66.3.3, 66.3.4 дэх заалт, 66.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 66.2-т заасан цахим хэлбэрээр гэж”, 39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсгийн дараа “Тайлбар: Энэ хуульд заасан “гарын үсэг” гэж Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4.1.14-т заасныг ойлгоно.” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

57,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйл дээр холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Төслийн 3 дугаар зүйл дээр холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

100. Зохиогчийн эрхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

101. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

102. Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

103. Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбоотой асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэг,” “149 дүгээр зүйлийн 149.1.1 дэх заалт, 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэг,” “294 дүгээр зүйлийн 294.6 дахь хэсэг, 296 дугаар зүйлийн 296.2 дахь хэсэг,” “443 дугаар зүйлийн 443.16 дахь хэсэг,” гэснийг тус тус хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

104. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсэг, 18.5.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “18.5.3 дахь заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

105. Өмгөөллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрийн хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “25 дугаар зүйлийн 25.3 дахь хэсэг” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Идэрбат гишүүн зарчмын зөрөөтэй санал гаргая гэж байна. Горимын санал гаргаж байна.

**Ц.Идэрбат:** Миний энэ төхөөрөмж нэг л болж өгөхгүй байна. Сольдог юм уу, сольж суудаг юм уу. Тэгэхгүй бол бас ингээд дэмжээд байгаа санал байна шүү дээ, уншигдахгүй байна.

**Э.Батиугар:** Идэрбат гишүүний горимын саналын дагуу санал хураалт явуулъя.

Байж байгаарай, байж байгаарай. Түрүүн Идэрбат гишүүний гаргасан горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүний горимын санал 57,1 хувиар дэмжигдлээ. Идэрбат гишүүний горимын санал дэмжигдсэн тул зарчмын зөрөөтэй саналаар ахин санал хураалт явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.



Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

2. Төслийн 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“2 дугаар зүйл. Өмгөөллийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.**

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

106. Патентын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 3 дугаар зүйлийг хасаж, зүйлийн дугаарыг өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

107. Прокурорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хороонд зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл. Прокурорын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан системийг ашиглан цахим хэлбэрээр” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3, 34.4 дэх хэсэг, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 33.1-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.**

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

108. Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан нийтийн мэдээллийн систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн зүйлийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

109. ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлтэй зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төсөл 1 дүгээр зүйлтэй холбогдон асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг,” гэснийг хасах. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Идэрбат гишүүн горимын санал гаргая.

**Ц.Идэрбат:** Сая бас энэ санал хураалтад оролцож чадсангүй. Дахин санал хураалгах бололцоо байна уу.

**Э.Батиугар:** Идэрбат гишүүний горимын саналын дагуу саяын саналаар хүчингүй болгох санал хураалт явуулъя. Санал хураалт.

Идэрбат гишүүний горимын санал 57,1 хувиар дэмжигдсэн тул түрүүчийн зарчмын зөрөөтэй саналыг ахиж явуулъя. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдолтой асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүр хэлэлцэж дууслаа.

110. Харьяатын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хороонд зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн “7 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэсний дараах “17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг,” гэснийг хасаж, “, эсхүл цахим хэлбэрээр” гэснийг “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

111. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж эхэлье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Би дэмжсэн ч гэсэн техник ажиллахгүй байсан тул саяын санал хураалтыг хүчингүй болгох горимын санал гаргаж, санал хураалт явуулъя. Санал хураалт.

Чинбүрэн гишүүн горимын санал гаргая.

**Ж.Чинбүрэн:** Энд анхаарал алдчихлаа, хүлцэл өчье. Тэгээд санал дахин хурааж өгөхийг хүсье.

**Э.Батиугар:** Чинбүрэн гишүүний горимын саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт.

Чинбүрэн гишүүний горимын санал 57,1 хувиар дэмжигдсэн тул зарчмын зөрөөтэй санал хураалтаа ахин явуулъя. Санал хураалт.

2. Төслийн 2 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“17.2.Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр болон энэ хуульд заасан цахим хэлбэрээр өргөдөл гаргасан тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага энэ хуулийн 12.4-т заасны дагуу ирүүлсэн баримт бичиг, эсхүл Нийтийн мэдээллийн дэд бүтцээр дамжуулан хүлээж авсан мэдээллийг хэвлэн авч, мэдээллийн санд оруулснаар хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэсэнд

тооцно.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

112. Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.10 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 21 дүгээр зүйлийн 21.11 дэх хэсэг, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 20.10-т заасан цахим хэлбэрээр” гэж, 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57 1 хувиар дэмжигдлээ.

2. Төслийн 2 дугаар зүйлийн “38.5.4” гэснийг “38.6.4” гэж өөрчлөх.

Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

113. Цагдаагийн албан тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.** Цагдаагийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтын “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 58 дугаар зүйлийн 58.6 дахь хэсгийн “даргань” гэсний дараа “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

114. Шүүхийн шинжилгээний дагуу хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулна.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“1 дүгээр зүйл.**Шүүх шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

115. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх, явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй санал. Шүүх шинжилгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналаар санал хураалт явуулъя. Саналыг танилцуулъя.

2. Төсөлд доор дурдсан агуулгатай 2 дугаар зүйл нэмж, зүйлийн дугаарыг өөрчлөх.

**“2 дугаар зүйл.** Шүүх шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсгийн “гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.” гэснийг “, эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулан цахим хэлбэрээр гаргана.” гэж өөрчилсүгэй.” Санал хураалт, санал гаргасан Хууль зүйн байнгын хороо.



Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

115. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1 дэх хэсгийн “төлөөлүүлэгчээс бичгээр” гэсний дараа “эсхүл цахим гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр”, 56 дугаар зүйлийн 56.4 дэх хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулсан цахим хэлбэрээр” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл цахим хэлбэрээр” гэж, 162 дугаар зүйлийн 162.6 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр” гэж, 180 дугаар зүйлийн 180.3 дахь хэсгийн “бичгээр” гэсний дараа “, эсхүл энэ хуулийн 162.6-д заасан цахим хэлбэрээр” гэж тус тус нэмсүгэй.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн “33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт,” гэснийг доор дурдсанаар өөрчлөн найруулж 3 дугаар зүйл болгон төсөлд нэмж тусгах:

“3 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналын хуулийн төсөл. Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

116. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж явуулъя. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 2 дугаар зүйлийн “заалт, 21 дүгээр зүйлийн 21.4 дэх хэсгийн” гэснийг “заалтын” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“3 дугаар зүйл.** Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.3 дахь заалтын “амаар болон бичгээр” гэснийг хассугай.” Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Саяын санал хураалт, саяын санал дэмжигдсэнгүй.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйл дээр асуулт асуух саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

117. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт асуух саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

1. Төслийн 1 дүгээр зүйлийн “Гэрчилгээг цахим хэлбэрээр олгож болно.” гэснийг “Гэрчилгээний мэдээллийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан авах боломжтой.” гэж өөрчлөх. Санал гаргасан Хууль зүйн байнгын хороо, санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

118. Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл

бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны саналыг танилцуулъя.

1. Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

119. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.

Төслийг хууль санаачлагчид буцаах. Санал хураалт.

Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

120. Хүн худалдахтай тэмцэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Төслийн 1 дүгээр зүйл дээр асуулт саналтай гишүүд байна уу? Алга байна. Хуулийн төслийн 2 дугаар зүйл дээр асуулт саналтай гишүүн байна уу? Алга байна.

*Хууль зүйн байнгын хорооны зарчмын зөрөөтэй саналыг танилцуулъя.*

*Хуулийн төслийг санаачлагчид буцаах. Санал хураалт.*

*Зарчмын зөрөөтэй санал 57,1 хувиар дэмжигдлээ.*

*Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.*

*Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдааныг хаасныг мэдэгдье.*

*Байнгын хорооны санал, дүгнэлтийг Чинбүрэн гишүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар боллоо.*

*Хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүддээ баярлалаа.*

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**